

# ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2025 оны сарын өдөр.

Нэг талаас Оросын холбооны Буриад улсын Жидийн аймгийн Политехникколлеж түүнийг төлөөлж байгууллагын дүрэмд заасныг үндэслэн захирал Раднаев Дашинама Нимаевич, цаашид /1-р тал/гэх, нөгөө талаас Монгол улсын Сэлэнгэ аймаг дахь ХААИС ийн харьяа Политехникколлеж үүнийг төлөөлж захирал Дүгэржавын Загдгочоо, цаашид «2-р тал» гэх, хамтад нь «талууд» гэх, нар энэхүү гэрээг дор дурдсанаар байгуулав.

## 1. ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО

1.1. Талууд нөхөрсөг харилцаагаа өргөжүүлэн гүнзгийрүүлэх, боловсрол, шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн чиглэлээр харилцаа холбоо тогтоож харилцан ашигтай хамтран ажиллахаар тохиролцов.

1.2 Талууд хамтын үйл ажиллагаагаа амжилттай хэрэгжүүлэхийн тулд санхүү, хүний нөөц, техник хэрэгсэл болон бусад нөөц бололцоогоо ашиглана гэж тохиролцов.

## 2. ХАМТРАН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ

2.1. Талууд хамтран ажиллахдаа бие биедээ эрх тэгш, итгэлцэл, шударга түншлэлийн зарчмыг үндэслэнэ.

2.2. Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх хүрээнд талууд оюуны үйл ажиллагааны эрхийг хамгаална.

2.3. Талууд энэхүү гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллахад шаардлагатай баримт бичиг, мэдээ мэдээлэл солилцох, түүнчлэн бие биенийхээ үйл ажиллагаанд мэдээллийн дэмжлэг үзүүлнэ.

## 3. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Талууд дараах чиглэлийн хүрээнд харилцан идэвхтэй хамтран ажиллах үүрэг хүлээнэ:

3.1.1.

- шинэ техник технологи, инноваци, AI ийг харилцан нэвтрүүлэх, туршлага судлах
- багш оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх
- сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр сурах бичгийг хамтран бэлтгэх, хэвлүүлэх, сургалт зохион байгуулах, мастер хичээл явуулах
- эрдэм шинжилгээний хурал, семинар, дугуй ширээний уулзалтыг хамтран зохион байгуулах
- ажил мэргэжлийн болон бусад уралдаан тэмцээнийг хамтран зохион байгуулах
- хамтарсан дадлага хийх гэх мэт

## 4. ГЭРЭЭНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ХУГАЦААГ СУНГАХ НӨХЦӨЛ

4.1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд 5 (таван) жилийн хугацаанд хүчинтэй байна.

4.1. Хэрэв хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө талуудын аль нь ч гэрээг цуцлах, нэмэлт өөрчлөлт оруулах, шинэ гэрээ байгуулах тухай мэдэгдээгүй бол гэрээг ижил хугацаанд, ижил нөхцөлөөр сунгасан гэж үзнэ.

4.2. Талуудын аль нэг нь гэрээг биелүүлэхээс дангаараа татгалзах эрхтэй буюу гэрээг цуцлах өдрөөс хуанлийн 30 (гучин) хоногийн өмнө нөгөө талдаа бичгээр мэдэгдэх болно.

4.3. Талууд бичгээр тохиролцсоны үндсэн дээр гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

## 5. БУСАД НӨХЦӨЛ

5.1. Талууд энэхүү гэрээний хэрэгжилтийг

1-р Талаас: Раднаев Дашинама Нимаевич, Оросын холбооны Буриад улсын Жидийн аймгийн Политехникколлежийн захирал.

Утасны дугаар: +7 (301) 3441765, E-mail: dmt@govrb.ru

2-р Талаас: Монгол улсын Сэлэнгэ аймаг дахь ХААИС ийн харьяа Политехник коллежийг төлөөлж захирал Дүгэржавын Загдгочоо нар хариуцан хангаж ажиллахаар харилцан тохиролцож гэрээ байгуулав.

Утасны дугаар ; 976-99492249 [selengeptc@gmail.com](mailto:selengeptc@gmail.com)

5.2. Энэхүү гэрээнд оруулсан бүх өөрчлөлт, нэмэлтийг талуудын нэмэлт гэрээгээр баталгаажуулсан бөгөөд энэ нь энэхүү гэрээний салшгүй хэсэг юм.

5.3. Гэрээг Тал тус бүрт нэг хувь, ижил хууль ёсны хүчинтэй хоёр хувь үйлдсэн.

## 6. ТАЛУУДЫН ХАЯГ.

1-Р ТАЛ	2-Р ТАЛ
<p><b>Оросын холбооны Буриад улсын Жидийн аймгийн Политехникколлеж түүнийг төлөөлж байгууллагын дүрэмд заасныг үндэслэн захирал Раднаев Дашинама Нимаевич,</b></p> <p>Албан ёсны хаяг: Буриад Улс, ш/х 671920, Жидийн аймаг, Петропавловка тосгон.Свердлова гудамж, 53 Утас: +7 (301) 3441765 E-mail: dmt@govrb.ru</p> <p>Захирал  / Д.Н. Раднаев/</p> 	<p><b>Монгол улсын Сэлэнгэ аймаг дахь ХААИС ийн харьяа Политехникколлеж үүнийг төлөөлж захирал Дүгэржавын Загдгочоо</b></p> <p>Албан ёсны хаяг: Монгол улс. Сэлэнгэ аймаг.Сүхбаатар сум.Баянхаан 4-р баг Утас. 976-99492249 <a href="mailto:selengeptc@gmail.com">selengeptc@gmail.com</a></p> <p>Захирал  Д.Загдгочоо. /проф/</p> 

ДОКУМЕНТ ПОДПИСАН  
ЭЛЕКТРОННОЙ ПОДПИСЬЮ

СВЕДЕНИЯ О СЕРТИФИКАТЕ ЭП

Сертификат 135955613336665976574499022560335136778487908086

Владелец Раднаев Дашинима Нимаевич

Действителен с 19.06.2023 по 18.06.2024